



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2026/3/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2026 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Батцогт Утас:7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:Bulgan@audit.gov.mn">Bulgan@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас:9905-7478 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: С.Цэдэнлхам Утас:9982-8263 Цахим хаяг: <a href="mailto:Tsedenkham@audit.gov.mn">Tsedenkham@audit.gov.mn</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс:7034-2580  
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 236  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ  
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА  
Г.АЛДАРМӨНХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөлөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн хангаж ажилласан байна.

**Аудитын гол асуудал**

Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль, Соёлын орон зай, Соёлын ажилтны өдөр зэрэг, Хангинахын шугуйн шагайн тойром, Айраг фестиваль зэрэг уламжлал болгон жил бүр зохион байгуулагддаг арга хэмжээнд салбарын албан хаагчдыг удирдан зохион байгуулж, амжилттай оролцсон байна.

**Бусад асуудлын хэсэг**

Хөгжмийн урлагаар дамжуулан иргэд, хүүхэд, залууст соёлын боловсрол олгох,

6326050302

тэдний авьяас билиг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилго бүхий "Амьд хөгжим" хөтөлбөрийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XI/75 дугаар тогтоолоор батлуулсан байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

## Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)			
	Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	14,091.7	16,253.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	131,698.1	106,639.3
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>145,789.8</b>	<b>122,893.0</b>
	Нийт өр төлбөрийн дүн	12.1	587.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	145,777.7	122,305.5
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>145,789.8</b>	<b>122,893.0</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	974,062.6	664,632.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	887,690.6	675,654.4
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>86,372.0</b>	<b>(11,022.1)</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн		(12,450.0)
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>86,372.0</b>	<b>(23,472.1)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,405.6	145,777.6
	Тайлант оны үр дүн	86,372.0	(23,472.1)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>145,777.6</b>	<b>122,305.5</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	894,877.8	657,684.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	869,877.8	645,234.8
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>25,000.0</b>	<b>12,450.0</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(25,000.0)</b>	<b>(12,450.0)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>364,058.5</b>	<b>450,479.6</b>
	Урсгал зардал	364,058.5	450,479.6
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>364,058.5</b>	<b>450,479.6</b>
	Улсын төсвөөс санхүүжих	363,698.5	450,479.6
	Туслах үйл ажиллагааны орлогоос	360.0	

### Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь соёл урлагийн салбарт хэрэгжиж буй бодлого, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, соёл урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэл хэрэгцээг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, төрөөс соёлын талаар баримтлах бодлогын баримт, бичиг, хөтөлбөр, дэд хөтөлбөрийн төсөл болосруулах, соёл урлагийн

байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжилт арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй.

Үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ.

Булган аймгийн соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь соёл урлагийн салбарт хэрэгжиж буй бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, соёл урлагийг хөгжүүлэх, иргэний соёлын эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, төрөөс соёлын талаар баримтлах бодлогын баримт бичиг, хөтөлбөр, дэд хөтөлбөрийн төсөл боловсруулах, соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг захиргааны болон мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах чиг үүрэгтэй.

Байгууллагын зохистой засаглал, дотоод хяналтын байдал, төсөв санхүүгийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, эрсдэлийн удирдлагаар хангах үндсэн дээр байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн ажиллагааны хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант онд аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 83 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, аймгийн Засаг даргаар 88.4 хувьтай үнэлүүлэн “маш сайн” үнэлгээ авсан байна.

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай, Соёлын тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдан гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангаж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль /шинэчилсэн найруулга;
- Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын холбогдох журам зааварт өөрчлөлт орсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **Дөрөв. Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэлээр Хойд бүсийн зөвлөлийн анхдугаар хуралдаан, Хойд бүсийн хөгжлийн чуулган, Засгийн газрын өргөтгөсөн хуралдааныг Булган аймагт зохион байгуулсан.

Нийгмийн халамж, цалин хөлстэй холбоотой 2025 онд төрийн албан хаагчийн цалин, тэтгэврийн хэмжээг 6 хувиар нэмэгдүүлсэн, "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тэтгэмжийг хоёр дахин нэмэгдүүлсэн, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, 792.0 мянган төгрөг болгосон, ахмад настны тухай хуульд ахмад настан хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тохиолдолд тэтгэврийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болох хууль, эрх зүйн өөрчлөлт мөрдөгдөж эхэлсэн байна.

### **Тав. Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2025 оны төсвийн жилд улсын төсвийн орлогын бүрдүүлэлтээс шалтгаалсан төсвийн зарлагын хязгаарлалт хийгдсэн, "Төсвийн сахилга бат, хариуцлагыг чангатгах тухай" Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

### **Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна. Нийцлийн асуудлаар илэрсэн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

#### **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд нийт 29 төрлийн 183 мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэхээс хугацаа болоогүй 5 мэдээлэл байна. 176 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 2 мэдээллийг хугацаа хоцроож, 5.0 сая төгрөгөөс дээш 720.6 сая төгрөгийн 19 орлогын, 72.1 сая төгрөгийн 8 зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж ажилласан байна.

## Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн анхаарах асуудал байхгүй.

## Найм. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 99.9 сая төгрөгийн алдаа, зөрчил<sup>1</sup> илэрснээс 99.6 сая төгрөгийн 4 алдааг залруулж, залруулагдаагүй 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо.

Нийт илрүүлсэн зөрчлөөс 0.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 6.4 сая төгрөгөөр бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

### Төлбөрийн акт

Илрүүлэлт: Төрийн албан хаагчийн ажилласан жилийн нэмэгдлийг 0.3 сая төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл хөлсийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 8.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(сая төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайланд өр төлбөрийг хасах дүнгээр илэрхийлж тайлагнасан.	1	0.6			1	0.6	1	0.6				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийгээгүй, зардалд бичилт хийж тайлагнасан.	1	96.7			1	96.7	1	96.7				
Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллого зохион байгуулах зардлаас томилолтын урьдчилгаа олгосныг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	1.8			1	1.8	1	1.8				
Түүх соёлын хөдлөх дурсгалын тооллого зохион байгуулах зардлаас томилолтын урьдчилгаа олгосноос Бугат, Хангал, Хялганат, Сэлэнгэ сумдад ажилласан томилолтын зардлын гүйцэтгэлийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар тайлагнаагүй.	1	0.6			1	0.6	1	0.6				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>99.7</b>			<b>4</b>	<b>99.7</b>	<b>4</b>	<b>99.7</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	0.3	1	0.3								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>0.3</b>	<b>1</b>	<b>0.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>				